

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

|   |    |
|---|----|
| 1. Аудитын гэрчилгээ .....  | 2  |
| 2. Аудитын тайлан.....  | 4  |
| 2.1. Оршил .....  | 4  |
| 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....  | 4  |
| 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....   | 4  |
| 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....   | 5  |
| 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... | 5  |
| 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....  | 5  |
| 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....   | 5  |
| 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....  | 6  |
| 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....   | 6  |
| 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....   | 6  |
| 2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....  | 7  |
| 2.12. Шилэн дансны мэдээлэл .....   | 7  |
| 2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....   | 7  |
| 2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....  | 7  |
| 3. Менежментийн захидал .....   | 8  |
| 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....  | 9  |
| 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....   | 9  |
| 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....  | 11 |
| 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....   | 13 |
| 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....   | 15 |
| 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....   | 15 |
| 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....   | 18 |
| 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....   | 19 |

### Товчилсон үгийн жагсаалт

|             |  |
|-------------|--|
| УСНББОУС    | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт                |
| АДБОУС      | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт                              |
| АОУС        | Аудитын Олон Улсын Стандарт  |
| ТБОНӨБАҮХАТ | Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай |



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

УЛСЫН МАЛ ЭМНЭЛЭГ, АРИУН  
ЦЭВРИЙН ТӨВ ЛАБОРАТОРИЙН  
ДАРГА Б.ГАНЗОРИГ ТАНАА

2020.02.27 № 06/626  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Б.Ганзориг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийг боловсронгуй болгох зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 11 дүгээр сарын 18-наас 2020 оны 02 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Дөлгөөнхайрхан уул Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн үйл ажиллагааны үндсэн зорилго нь Монгол Улсын малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль болон малын эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх, улсын хэмжээнд мал, амьтны элдэв өвчин, хорогдлыг оношлох, гадаад, дотоодын зах зээлд борлуулах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн болон хашаа байр, тэжээл, ус, хөрс, ургамалд ариун цэвэр, эрүүл ахуйн үзлэг, шинжилгээ хийж дүгнэлт гаргах, баталгаажуулан гэрчилгээ олгох, орон нутгийн мал эмнэлгийн шинжилгээний байгууллагуудыг арга зүйн удирдлагаар хангахад оршино.

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мал амьтны элдэв халдварт өвчнийг оношилж илрүүлэх, шинжлэн эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, чанарын үнэлгээ хийх, хяналт тавих,
- Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнд үзлэг хийж, зөвшөөрөл олгох

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр А-385 тоот тушаалаар “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” шинээр батлагдсан байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа [vet.dynamic.mn](http://vet.dynamic.mn) онлайн программ хангамж ашигладаг байна.

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 9 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

#### **2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр завсар үеийн буюу 2019 оны

09 дүгээр сарын 30-ны өдрийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоосон. Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,639,023.6 мянган төгрөгөөс тооцон 32,780.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 3,176,398.3 мянган төгрөгийн 2 хувь буюу 63,528.0 мянган төгрөгөөр тооцсон болно.

## 2.8. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 204,710.6 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар буурсан байна. Бараа материал өссөн боловч, үндсэн хөрөнгө буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт  | /мянган төгрөг/    |                    |                   |
|---|--------------------|--------------------|-------------------|
|   | Эхний үлдэгдэл     | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт          |
| Б   | 1                  | 2                  | 3=2-1             |
| Мөнгөн хөрөнгө                                    | -                  | -                  | -                 |
| Авлага  | 117,830.1          | 109,320.3          | -8,509.8          |
| Урьдчилгаа  | -                  | -                  | -                 |
| Бараа материал                                    | 1,679,683.0        | 2,011,955.3        | 332,272.3         |
| Үндсэн хөрөнгө                                    | 6,321,502.0        | 5,793,028.8        | -528,473.2        |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>8,119,015,1</b> | <b>7,914,304.4</b> | <b>-204,710.7</b> |
| Өр төлбөр   | 734.6              | 734.6              | -                 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 6,171,083.5        | 6,171,083.5        | -                 |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>8,119,015,1</b> | <b>7,914,304.4</b> | <b>-204,710.7</b> |

Бараа материал дансны үлдэгдэл нь дулааны аргаар боловсруулсан мах, түүхий эдийн экспорт нэмэгдсэнтэй холбоотойгоор экспортын шинжилгээнүүд хийгдэх болсноор шаардлагатай бараа материал, эм урвалжийн худалдан авалт хийж, үлдэгдэл өссөн байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл нь 990.0 мянган төгрөгийн онлайн санхүүгийн программ шинээр худалдан авсантай холбоотойгоор өссөн.

## 2.9. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн тайлант онд 261,913.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 244,994.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 93.5 хувиар биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

## 2.10. АУДИТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 9 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл тодорхойлж нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 9,297.4 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Тайлант онд тендерт шалгарсан "Мон вет мед" ХХК-тай байгуулсан гэрээний дүн болох 108,889.2 мянган төгрөгт гүйцэтгэлийн баталгаа гаргуулж аваагүй байна. Энэ нь ТБОНӨБАҮХАТухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4-д "Захиалагч дор дурдсан нөхцөлд гүйцэтгэлийн баталгаа ирүүлэхийг гүйцэтгэгчээс шаардана, 43.4.2-д "100 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах; мөн 43 дугаар зүйлийн 43.3-д "Гүйцэтгэлийн баталгаа нь гэрээ дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээлцэх хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, барагдуулахаар өгсөн зөвлөмжийн бүрэн хэрэгжүүлээгүй байна. Тайлант оны эцэст 3,118.3 мянган төгрөгийн авлага, 734.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 "Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын Үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

#### **2.11. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Дараагийн аудитаар бараа материалын орлого, зарлагыг илүү нарийвчлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлангуудын мэдээллүүдийг хугацаанд нь, санхүүгийн тайлан мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

#### **2.13. ӨМНӨХ АУДИТААР ӨГСӨН АКТ, АЛБАН ШААРДЛАГА, ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,583.3 мянган төгрөгийн зөрчилд 953.2 төлбөрийн акт тогтоосноос 953.2 мянган төгрөгийг барагдуулсан байна.

Нийт 2 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 54.9 хувьтай байна.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Үндсэн хөрөнгө болон бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийг санхүүгийн тайлангийн дүнтэй тулгахад зөрүүтэй байгаа нь нягтлан бодох бүртгэлийн программыг шинээр ашиглаж эхэлсэнтэй холбоотой байна.

3.1.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан, тодруулга болон туслах тайлангуудад тусгасан үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл хоорондын уялдаа алдагдах, бодитой бус бүртгэх

3.1.3 Өгсөн зөвлөмж: Байгууллага нь 2019 оноос шинээр "Гүүд Софт" ХХК-ний [vet.dynamic.mn](http://vet.dynamic.mn) нягтлан бодох бүртгэлийн програмыг ашиглаж эхэлсэнтэй холбоотойгоор зарим мэдээллийг боловсруулахдаа нэмэлт тохиргоог хийх шаардлагатай байгаа тул программаа сайжруулах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Санхүүгийн шинэ нэвтэрсэн програмын алдаа дутагдлыг засаж залруулж сайжруулахаар дээд байгууллага болон програм нийлүүлсэн компанитай байнга хамран ажиллаж байгаа ирэх оноос алдаа гарахгүй байх талаас анхааран ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код  | Балансын үзүүлэлт                  | Эхний үлдэгдэл                 | Эцсийн үлдэгдэл                |
|-------------|------------------------------------|--------------------------------|--------------------------------|
| <b>1</b>    | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>     | <b><u>1,797,513,119.19</u></b> | <b><u>2,121,275,637.27</u></b> |
| <b>31</b>   | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>              | -                              | -                              |
| <b>311</b>  | <b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>  | -                              | -                              |
| <b>312</b>  | <b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>  | -                              | -                              |
| <b>33</b>   | <b>АВЛАГА</b>                      | 117,830,099.30                 | 109,320,305.65                 |
| 33100       | Ажиллагчидтай холбогдсон авлага    | -                              | 3,118,303.76                   |
| <b>335</b>  | <b>Бусад авлага</b>                | 117,830,099.30                 | 106,202,001.89                 |
| 3351        | Байгууллагаас авах авлага          | 117,746,477.30                 | 106,202,001.89                 |
| 3352        | Хувь хүмүүсээс авах авлага         | 83,622.00                      | -                              |
| <b>35</b>   | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>              | 1,679,683,019.89               | 2,011,955,331.62               |
| <b>351</b>  | <b>Түүхий эд материал</b>          | 1,617,957,523.32               | 1,935,196,189.74               |
| 35110       | Тусгай зориулалттай материал       | 529,138,156.91                 | 446,622,422.45                 |
| 35130       | Эм боох материал                   | 1,088,819,366.41               | 1,488,573,767.29               |
| <b>354</b>  | <b>Хангамжийн материал</b>         | 60,345,496.57                  | 76,099,141.88                  |
| 35420       | Аж ахуйн материал                  | 16,999,652.90                  | 13,130,117.90                  |
| 35430       | Сэлбэг хэрэгсэл                    | 10,231,769.14                  | 8,906,422.00                   |
| 35440       | Түлш, шатах тослох материал        | -                              | 1,688,530.00                   |
| 35470       | Бусад хангамжийн материал          | 33,114,074.53                  | 52,374,071.98                  |
| 35600       | Мал амьтад                         | 1,380,000.00                   | 660,000.00                     |
| <b>2</b>    | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b> | <b><u>6,321,501,950.94</u></b> | <b><u>5,793,028,783.51</u></b> |
| <b>39</b>   | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>              | 6,321,501,950.94               | 5,793,028,783.51               |
| <b>392</b>  | <b>Биет хөрөнгө</b>                | 5,877,636,910.94               | 5,348,322,243.51               |
| 39201       | Барилга, байгууламж, орон сууц     | 1,905,142,660.95               | 1,905,142,660.95               |
| 39202       | Хуримтлагдсан элэгдэл              | -2,781,903.36                  | -74,611,745.40                 |
| 39203       | Авто-тээврийн хэрэгсэл             | 342,436,539.00                 | 342,436,539.00                 |
| 39204       | Хуримтлагдсан элэгдэл              | -266,362,379.24                | -282,789,252.56                |
| 39205       | Машин тоног төхөөрөмж (компьютер)  | 112,190,615.17                 | 126,050,215.17                 |
| 39206       | Хуримтлагдсан элэгдэл              | -88,465,601.61                 | -96,735,181.49                 |
| 39207       | Тавилга, аж ахуйн эд хогшил        | 763,910,319.61                 | 768,830,319.61                 |
| 39208       | Хуримтлагдсан элэгдэл              | -425,393,321.69                | -492,490,072.46                |
| 39209       | Зам, гүүрийн байгууламж            | 5,388,380,747.31               | 5,447,967,747.31               |
| 39210       | Хуримтлагдсан элэгдэл              | -2,926,420,765.21              | -3,370,478,986.62              |
| 39216       | Дуусаагүй барилга, байгууламж      | 1,075,000,000.00               | 1,075,000,000.00               |
| <b>393</b>  | <b>Биет бус хөрөнгө</b>            | 443,865,040.00                 | 444,706,540.00                 |
| 39301       | Програм хангамж                    | 770,000.00                     | 1,760,000.00                   |
| 39302       | Хуримтлагдсан элэгдэл              | -770,000.00                    | -918,500.00                    |
| 39303       | Бусад биет бус хөрөнгө             | 445,403,500.00                 | 445,403,500.00                 |
| 39304       | Хуримтлагдсан элэгдэл              | -1,538,460.00                  | -1,538,460.00                  |
| <b>3</b>    | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b> | <b><u>8,119,015,070.13</u></b> | <b><u>7,914,304,420.78</u></b> |
| <b>4</b>    | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>              | <b><u>734,560.01</u></b>       | <b><u>734,560.01</u></b>       |
| <b>41</b>   | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>   | 734,560.01                     | 734,560.01                     |
| <b>413</b>  | <b>Өглөг</b>                       | 734,560.01                     | 734,560.01                     |
| <b>4136</b> | <b>Бусад өглөг</b>                 | 734,560.01                     | 734,560.01                     |
| 41361       | Байгууллагад төлөх өглөг           | 734,560.01                     | 734,560.01                     |

| Дансны код | Балансын үзүүлэлт   | Эхний үлдэгдэл                 | Эцсийн үлдэгдэл                |
|------------|---|--------------------------------|--------------------------------|
| <b>5</b>   | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b><u>8,118,280,510.12</u></b> | <b><u>7,913,569,860.77</u></b> |
| <b>51</b>  | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | 8,118,280,510.12               | 7,913,569,860.77               |
| 511        | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 6,171,083,458.16               | 6,171,083,458.16               |
| 51101      | Өмч: - төрийн   | 6,163,584,432.21               | 6,163,584,432.21               |
| <b>512</b> | <b>Хуримтлагдсан үр дүн</b>   | 644,239,653.35                 | 439,529,004.00                 |
| 51210      | Өмнөх үеийн үр дүн  | -151,350,346.54                | 644,239,653.35                 |
| 51220      | Тайлант үеийн үр дүн  | 795,589,999.89                 | -204,710,649.35                |
| 51300      | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 1,302,957,398.61               | 1,302,957,398.61               |
| <b>6</b>   | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b><u>8,119,015,070.13</u></b> | <b><u>7,914,304,420.78</u></b> |

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код  | Үзүүлэлт  | Өмнөх он                | Тайлант он              |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>  | <b>3,306,036,826.38</b> | <b>2,971,687,650.11</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>  | <b>223,240,372.00</b>   | <b>1,117,938,483.45</b> |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>  | 215,140,372.00          | 1,117,938,483.45        |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого  | 215,140,372.00          | 1,117,938,483.45        |
| 1200041     | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих   | 215,140,372.00          | 244,994,405.00          |
| 1200042     | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих   | -                       | 480,000.00              |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого   | -                       | 872,464,078.45          |
| <b>122</b>  | <b>Тусламжийн орлого</b>  | 8,100,000.00            | -                       |
| 122002      | Хандив тусламж /гадаад/   | 8,100,000.00            | -                       |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>  | <b>3,082,796,454.38</b> | <b>1,853,749,166.66</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>  | 1,032,917,900.00        | 1,264,344,950.00        |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт   | 461,023,900.00          | 1,264,344,950.00        |
| 131005      | Хөрөнгийн санхүүжилт  | 571,894,000.00          | -                       |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>  | 1,171,543,155.56        | 589,404,216.66          |
| 131101      | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж   | 490,863,869.66          | 155,129,796.66          |
| 131103      | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 12,400,000.00           | -                       |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө  | 544,276,000.00          | 325,203,720.00          |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                                | 124,003,285.90          | 109,070,700.00          |
| <b>1330</b> | <b>Төсвийн захирагчдаас</b>   | 878,335,398.82          | -                       |
| 133003      | Хөрөнгийн   | 878,335,398.82          | -                       |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>  | <b>2,346,007,183.58</b> | <b>3,176,398,299.46</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>2,346,007,183.58</b> | <b>3,176,398,299.46</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>  | 2,287,839,642.56        | 3,054,540,307.54        |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>  | 485,631,023.29          | 609,036,228.15          |
| 210101      | Үндсэн цалин  | 371,274,895.29          | 517,946,070.15          |
| 210102      | Нэмэгдэл  | 5,652,200.00            | -                       |
| 210103      | Унаа хоолны хөнгөлөлт   | 11,722,000.00           | -                       |
| 210104      | Урамшуулал  | 70,674,336.00           | -                       |
| 210105      | Гэрээт ажлын хөлс   | 26,307,592.00           | 91,090,158.00           |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>   | 64,518,887.04           | 79,364,340.00           |
| 210201      | Тэтгэврийн даатгал  | 41,858,387.04           | 57,406,450.00           |
| 210202      | Тэтгэмжийн даатгал  | 4,295,614.00            | 6,172,599.00            |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал   | 9,626,581.00            | 4,866,441.00            |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал  | 1,184,805.00            | 1,198,280.00            |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал   | 7,553,500.00            | 9,720,570.00            |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>  | 93,259,131.30           | 110,253,917.11          |
| 210301      | Гэрэл, цахилгаан  | 78,655,126.30           | 89,655,312.00           |
| 210302      | Түлш, халаалт   | 14,604,005.00           | 17,628,605.11           |
| 210303      | Цэвэр, бохир ус   | -                       | 2,970,000.00            |
| <b>2104</b> | <b>Хангамж, бараа материалын зардал</b>   | 79,053,069.50           | 125,775,394.83          |
| 210401      | Бичиг хэрэг   | 2,581,964.00            | 2,705,000.00            |
| 210402      | Тээвэр, шатахуун  | 69,320,427.00           | 68,071,465.00           |
| 210403      | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр  | 1,333,833.98            | 407,576.61              |
| 210406      | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс   | 5,816,844.52            | 966,801.00              |
| 210408      | Бараа материал акталсны зардал  | -                       | 53,624,552.22           |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>   | 535,313,232.22          | 732,159,907.46          |
| 210501      | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл   | 534,738,732.22          | 728,912,707.46          |

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2019 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| Дансны код  | Үзүүлэлт   | Өмнөх он               | Тайлант он             |
|-------------|--|------------------------|------------------------|
| 210503      | Нормын хувцас, зөөлөн эдлэл  | 574,500.00             | 3,247,200.00           |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                             | <b>27,184,360.50</b>   | <b>97,781,621.00</b>   |
| 210601      | Багаж, техник, хэрэгсэл  | 1,200,000.00           | -                      |
| 210603      | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл   | 843,753.50             | -                      |
| 210604      | Урсгал засвар  | 25,140,607.00          | 97,781,621.00          |
| <b>2107</b> | <b>Томилолт, зочны зардал</b>  | <b>206,839,306.00</b>  | <b>132,736,862.00</b>  |
| 210701      | Гадаад албан томилолт  | -                      | 5,977,712.00           |
| 210702      | Дотоод албан томилолт  | 206,839,306.00         | 126,759,150.00         |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | <b>183,086,040.30</b>  | <b>464,802,628.00</b>  |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 159,891,217.30         | 439,527,228.00         |
| 210802      | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 1,188,000.00           | 4,400,000.00           |
| 210803      | Даатгалын үйлчилгээ  | 2,472,098.00           | 2,475,000.00           |
| 210804      | Тээврийн хэрэгслийн татвар   | 370,530.00             | 352,500.00             |
| 210805      | Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 110,000.00             | 82,000.00              |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 17,572,603.00          | 16,484,300.00          |
| 210807      | Газрын төлбөр  | 1,481,592.00           | 1,481,600.00           |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | <b>612,954,592.41</b>  | <b>702,629,408.99</b>  |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 75,829,490.05          | 93,904,078.90          |
| 210903      | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол                                   | 537,125,102.36         | 607,829,767.42         |
| 210904      | Найдваргүй авлагын алдагдал  | -                      | 895,562.67             |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | <b>58,167,541.02</b>   | <b>121,857,991.92</b>  |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | <b>9,250,000.00</b>    | <b>26,390,564.00</b>   |
| 213204      | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал                       | 9,250,000.00           | -                      |
| 213207      | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                  | -                      | 17,622,564.00          |
| 213209      | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | -                      | 8,768,000.00           |
| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                   | <b>48,917,541.02</b>   | <b>95,467,427.92</b>   |
| 213303      | Төвлөрүүлэх шилжүүлэг  | 48,917,541.02          | 95,467,427.92          |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>                            | <b>960,029,642.80</b>  | <b>-204,710,649.35</b> |
| <b>225</b>  | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>                               | <b>164,439,642.91</b>  | <b>-</b>               |
| 225007      | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал                                    | 164,439,642.91         | -                      |
| <b>4</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>                      | <b>-164,439,642.91</b> | <b>-</b>               |
